

Нэр томъёоны оноолт, орчуулгын зарим асуудлууд

Г.Болормаа* (ШУТИС)

Монгол улс БНХАУ-ын хамтын ажиллагаа идэвхжиж, үүнийг дагаад хятад хэлний мэргэжлийн салбарын үг хэллэг, нэр томъёоны орчуулгын асуудал чухал болж байна.

Нэр томъёоны судалгааны ажлууд олон хэлээр ялангуяа орос, англи хэлүүдээр ихэвчлэн хийгдсэн байдаг. Гэвч хятад хэлний нэр томъёоны судалгааны ажлууд маш хомс байна. Судалгааны ажлын жишээнүүдээр монгол хятад уулын ашиглалтын салбарын нэр томъёонуудыг сонгон авч хийлээ. Монгол, хятад хэлээр уулын салбарын бичиг баримт, бүтээл орчуулах, нэр томъёог орчуулах, оноох шаардлага хамтын ажиллагаа амьдралын хэрэгцээнээс урган гарч байна.

Нэр томъёоны оноолт, орчуулгын талаар судалж байгаа учраас эхлээд бүтцийн талаас нь авч үзэх хэрэгтэй юм. Хятад хэлний нэр томъёо нь ихэвчлэн нийлмэл үгнээс бүрдсэн байдаг. Учир нь хятад хэлний онцлог болон ханзаар үгийг нийлмэл байдлаар илэрхийлдэгтэй холбоотой. Нийлмэл үгнээс бүрдсэн хятад нэр томъёо нь нийт түүвэрлэсэн жишээний 90 орчим хувийг эзэлж байгаа нь судалгаагаар харагдлаа. Нийлмэл үгнээс бүрдсэн нэр томъёог 2 ба түүнээс дээш үгнээс бүтсэн нэр томъёо хэмээн дахин ангилж болмоор санагдлаа. Жишээ нь:

Хятад	Монгол
1. 支护, 支架, 支柱	/Хамгаалалтын хүрээ, багана/Бэхэлгээ
2. 浮选, 浮游选	/Хөвүүлэн баяжуулах/Флотацаар баяжуулах
3. 重力选 баяжуулалт	/Хүндийн хүчээр баяжуулах/Гравитацаар
4. 水力分级	/Усны хүчээр ангилах /Гидравлик ангилалт
5. 陷落顶增量	Нураалтын алхам, авалтын өргөн

* “Сэн Лизэ” бүрэн дунд сургуулийн Хятад хэлний тэнхимийн эрхлэгч, ШУТИС-ийн докторант

Дан үгнээс бүрдсэн уул уурхайн хятад нэр томьёо нь зөвхөн химийн элементүүдэд ажиглагддаг. Жишээ нь: 氮 Азот, 砷 Арсен, 铅 Хар тугалга, 锌 Цайр г.м.

Мөн эдгээр элементүүдийн зарим хэсэг нь олон улсын нэрийг нь галигчлан авсан учраас харь үгийг хэрэглэх гэсэн аргад хамааруулж үзэж болох талтай.

Хятад хэлэнд дагаврын болон угтварын аргаар нэр томьёог үүсгэж байгаа тохиолдол байхгүй байгаа нь бас нэг онцлог байна. Энэ тохиолдол нь зөвхөн нэр томьёоны хувьд байхгүй болохоос бусад энгийн үг залгаврын аргаар бүтсэн нь бий.

Бүтцийн талаас нь ийм байна. Одоо орчуулгын талаас нь ярья.

Орчуулгын онол практикийн хүрээнд дараах аргуудыг өргөнөөр хэрэглэдэг. Үүнд:

1. Дүйлгэн орчуулах арга
2. Галигчлан буулгах арга
3. Хуулбарлах буюу үгчлэн орчуулах арга
4. Тайлбарлан орчуулах арга

Дүйлгэн орчуулсан нэр томьёо

Энэ нь дүйлгэн орчуулах хамгийн түгээмэл болоод сайн арга юм. Жишээ нь:

Хятад	Монгол
1. 永久煤柱损失	Нүүрсний багалан дах тогтмол хаягдал
2. 服务年限	Уурхайн ажиллах нийт хугацаа
3. 工作面	Цэвэрлэгээний мөргөцөг буюу лав

Галигчлан буулгасан нэр томьёо

Монгол хэлний нэр томьёонд орос хэлнээс болон орос хэлээр дамжин орж ирсэн буюу галигчлан буулгасан үгс нилээд байдаг. Харин хятад хэлнээс монгол хэлэнд галигчлан авсан нэр томьёо байхгүйг энд дурьдах хэрэгтэй.

Гэхдээ зөвхөн нэр томьёоны хувьд галигчлан буулгасан үг байдаггүй. Энгийн хэрэглээний нэр үг хятад хэлнээс монгол хэлэнд галигчлан буусан нь элбэг тохиолддог. Жишээ нь: Лууван 萝卜 Luo bo, Шийгуа 西瓜 Xi gua, яндан 烟筒 Yan tong, гүнж 公主 Gong zhu, дааман хаалга 大门 Da men, жинтүү 枕头 Zhen tou г.м.

Хятад хэлний уул уурхайн салбарын нэр томьёоны хувьд орос, англи зэрэг ер нь гадаад хэлнээс зээлдэн авсан нэр томьёо байдаггүй гэж судалгааны явцад ажиглагдсан. Үүгээр хятад хэлний зөвхөн уул уурхайн биш, бусад аль ч салбарын нэр томьёоны орчуулгын онцлог харагдаж байгаа юм.

Тийм учраас хятад хэлнээс монгол хэлнээ уул уурхайн салбарын нэр томъёог орчуулах явдал маш түвэг бэрхшээлтэй байгаа юм.

Хуулбарлах буюу үгчлэн орчуулсан нэр томъёо

Энэ аргыг нийлэмж үгээс бүрдсэн нэр томъёог орчуулахад ихэвчлэн хэрэглэж байна. Жишээ нь:

Хятад	Монгол
1. 开采工程	Олборлолтын ажил
2. 钻研防暴工作	Өрөмдлөг тэсэлгээний ажил
3. 矿山救护操作, 矿山救护作业	Уурхайн аврах ажил
4. 防爆工作	Тэсэлгээний ажил
5. 井下矿业工作	Далд уурхайн ажил

Дээрх жишээнүүдээс харахад монгол хэлнээ ажил гэсэн нэг ижил үгээр бүх ажлыг тэмдэглэсэн байхад хятад хэлнээ “ажил” гэдэг үг 工作, 工程, 作业, 操作 гэсэн 4 янзын ханзаар тэмдэглэсэн байгааг ажиглалаа.

Тайлбарлан орчуулсан нэр томъёо

Тайлбарлан орчуулах арга нь нэр томъёонд тавигдах “товч” байх зарчимд нийцдэггүй тул энэ арга нь нэр томъёо орчуулахад төдийлөн ашиглагдахгүй байгаа нь судалгааны ажлын явцад ажиглагдлаа.

Гэвч хятад хэлний хувьд нэр томъёог тайлбарлан буулгах тохиолдол нь уулын салбарын ормол /гадаад нэр томъёо/ нэр томъёог орчуулахад түлхүү ашиглаж байна. Жишээ нь:

Хятад	Монгол
1. 堆积机	/Абзатцер/Овоолон цуглуулдаг машин
2. 重力选	/Гравитацаар баяжуулах/Хүндийн хүчээр баяжуулах, живүүлэн баяжуулах
3. 分级机	/Грейдер/Зэрэглэн ангилах машин
4. 液压	/Гидравлик/Шингэний даралт
5. 地工艺	/Геотехнологи/Газрын технологи

Сонгон авсан жишээнүүдийг судалгааны явцад ажиглалт хийгээд доорх байдлаар ангилж болмоор санагдлаа. Үүнд:

1. *Тоног тохөөрөмжийн нэр томъёо* Жишээ нь: Абзатцер, агаар зөөгч, агаар хураагуур, ангилагч (грейдер), экскаватор г.м.

2. *Химийн нэр томьёо* Жишээ нь: Метан, азот, алт, манган, арсен, хар тугалга, торч, уран г.м.
3. *Үйл ажиллагааны нэр томьёо* Жишээ нь: Аврах ажиллагаа, нэвтрэлтийн арга, ерөнхий агааржуулалт, далд уурхайн ажиллагаа, өрөмдлөг тэсэлгээний ажил, ашиглалтын геотехнологийн арга, ил ашиглалтын арга г.м.

Мөн энгийн хэрэглээний 3 толь бичгээс уулын ашиглалтын нэр томьёог түүвэрлэн судалгаа хийж үзлээ. Толь бичгүүд дэх мэргэжлийн үг хэллэг, нэр томьёоны орчуулга оновчгүй байсан гэж үзэж байна. 强度 гэсэн үг нь уул уурхайн нэр томьёонд “батшил” хэмээн хэрэглэгддэг бол хятад хэлнийх нь үндсэн утга нь энгийн хэрэглээний 3 толь бичигт эрчим, хүч, эрч, интенсивность буюу эрчим, хүч, батшил гэж тус тус орчуулсан байгаа нь энгийн үг нэр томьёо болж байгаагийн тод жишээ юм.

Дүгнэлт

1. Монгол, хятад хэлээр гарсан уул уурхайн үг, хэллэг нэр томьёоны толь хараахан гараагүй учир түүвэрлэсэн жишээгээ орос, англи хэлээр дамжуулан орчуулан буулгалаа.
2. Хятад хэлний цөөн тооны нэр томьёо нь дан үгнээс бүтсэн бөгөөд нийлмэл үгнээс бүтсэн нь түүвэрлэн авсан жишээний 95 орчим хувийг эзэлж байна. Түүнчлэн уулын ашиглалтын хятад нэр томьёо бүтэх дагаврын арга огт байдаггүйгээрээ монгол хэлний нэр томьёоноос онцлог байна.
3. Уулын ашиглалтын монгол нэр томьёонд латин, грек гаралтай үгс их байхад хятад хэлний нэр томьёонд байхгүй байна. Монгол хэлний хувьд үг нийлэх болон ухагдахууныг илэрхийлсэн байхад хятад хэлэнд тайлбарласан шинж чанартай байна.
4. Хятад хэлний нэр томьёоны орчуулгын хувьд дүйлгэх болон үгчлэн орчуулах аргуудыг маш өргөнөөр ашигладаг нь судалгааны явцад ажиглагдлаа. Химийн зарим хятад нэр томьёо нь олон улсын нэр томьёог галиглан авсан гэж үзлээ.
5. Түүвэрлэсэн жишээнүүдээ энгийн хэрэглээний “Д.Болдбаатар “Хятад-Монгол толь бичиг”, УБ, 2010 он, Хятад Монгол толь” 1982 年, “Китайско-Русский словарь”, Бээжин, 2008 он” зэрэг толь бичгүүдээс харахад уул уурхайн салбарын нэр томьёо маш бага, орчуулгын хувьд оновчгүй байсан гэж үзэж байна.

Иймд монгол-хятад, хятад-монгол хэлний уул уурхайн салбарын үг хэллэг, нэр томьёоны толийг стандартын дагуу гаргаж практикт өргөн хэрэглэх нь зайлшгүй шаардлагатай байгаа юм.